



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/114

Улаанбаатар хот

Малын түүвэр судалгаа зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/764 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хагас жилийн малын түүвэр судалгаа"-г 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2. Тооллого зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Х.Цогцэцэг	Засаг даргын орлогч
Гишүүд:	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	П.Цэрэнням	Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч
	Х.Дуламсүрэн	Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн эрсдэлийн удирдлагын үнэлгээ дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч

Нарийн бичгийн
дарга:

Д.Ундрал

Дүүргийн Статистикийн ахлах
мэргэжилтэн

3. Тооллогын явцад хяналт тавих, мэргэжил арга зүйн, зөвлөгөө өгч ажиллахыг ажлын хэсэг (Х.Цогцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД